

Байнгын хорооны 2022 оны .... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

***Товч удирдамж:*** *Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг шуудангаар болон цахимаар тус тус Байнгын хороонд явуулна.*

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **1.1** | **Эцэг/эхийн нэр:** Түдэв<br>**Ургийн овог:** Дүйнхэр тэргүүтэн<br>**Нэр:** Баясгалан<br>**Хүйс:** Эр<br>**Төрсөн он:** 1977<br>**Төрсөн газар:** Архангай аймгийн Ихтамир сум<br>**Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:** УБ хот, Баянгол дүүрэг, 33-р хороо, 71-26 тоот */Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/* |
| **1.2** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал** |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн |
| **1.3** | **Нэр дэвшүүлсэн албан байгууллага**<br>Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо |
| **1.3** | **Иргэний харьяалал**<br>Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих/.<br>Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих/. |
| | Тийм |
| **1.4** | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дараалаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. |
| | 2004 онд Улаанбаатарын Их сургуулийн докторантур (F-20052116)<br>2000 онд Улаанбаатарын Их сургуулийн магистрантур (№2017/47)<br>1994-1998 онд “Гурван-Эрдэнэ” багшийн дээд сургуулийг монгол хэл, уран зохиолын багш, бакалавр (1998.06.04. D-9805809) |
| **1.7** | **Эрхэлсэн ажил** |
| | 2000 оны 5-р сарын 1-ний өдрөөс эхлэн ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд скторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтнаар одоог хүртэл.<br>Ажил олгогч захирал Ж.Бат-Ирээдүй, утас: 99116129, batireedui@mas.ac.mn |
| **1.8** | **Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал**<br>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. |
| | Үгүй |
| **1.9** | **Эрүүгийн хариуцлага**<br>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж |

| | |
|---|---|
| | хариулсан бол товч тайлбарыг бичих/ |
| | Үгүй |
| **1.10** | **Яллагдагчаар татагдсан эсэх**<br>Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/. |
| | Үгүй |
| **1.11** | **Сахилгын шийтгэлийн талаар**<br>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар бичих/. |
| | Үгүй |
| **1.12** | **Төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br><br>-Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар бичнэ. |
| | 2016 оны 9-р сарын 1-ний өдрөөс одоо хүртэл Шинжлэх ухааны байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны даргаар ажиллаж байна. |
| **1.13** | **Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ**<br><br>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br><br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br><br>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.<br><br>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.<br><br>**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана. |
| | 1. “Жангар” туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа. Уб., 2010. 183 х.<br>2. Монгол туулийн сэдэв, байгууламжийн судалгаа. Уб., 2010. 165 х.<br>3. “Жангар”-ын хувилбаруудын харьцуулсан судалгаа. Уб., 2019. 124 х.<br>4. Эмхэтгэл, товхимол, хамтын бүтээл нийт 31, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, тэмдэглэл, шүүмж, нийтлэл, өмнөх үг нийт 100 гаруйг бичиж нийтлүүлсэн.<br><br>- 2013 онд зохион байгуулагдсан “Төв Азийн тууль” симпозиум-их наадмаас гаргасан зөвлөмжийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн нэрийн өмнөөс бичсэн. Энэ зөвлөмж тус наадмын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэлд нийтлэгдсэн. Зөвлөмжид монгол туулийг |

| | |
|---|---|
| | сэргээн уламжлуулах, судалгаа шинжилгээг хөгжүүлэх асуудлыг голчлон тусгасан.<br>- 2019 онд МБШУҮЭХ-ны дүрмийн төсөл боловсруулах ажлын хэсэг, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн дотоод журам боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан.<br>- МБШУҮЭХ ба БШУЯ-ны 2015-2017, 2017-2019, 2020-2022 оны Хамтын хэлэлцээр байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.<br>- 2022 онд МҮЭХ-ны дүрмийн төсөл боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан.<br>- Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ҮЭ-ийн хороонуудын Хамтын гэрээний төсөл боловсруулах ажлыг удаа дараа ахалж ажилласан.<br>- 2021 онд Эрдэм шинжилгээний ажилтнуудын аттестатчилалын журам боловсруулах ажлын хэсэгт салбарын ҮЭ-ийг төлөөлөн оролцож ажилласан.<br>- Сүүлийн 5 жилийн хугацаанд гадаад, дотоодын 10 гаруй эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн.<br>- Монгол тууль, "Жангар" туулийн талаар мэргэжсэн судлаачийн хувьд олон нийтэд зориулсан 6 лекц уншсаны олонхыг цар тахлын үед онлайнаар хийсэн.<br>- Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шинжлэх ухааны салбарын ажилтнуудын цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлаар жил бүр телевиз, мэдээний сайтуудад яриа өгч байснаас гадна олон тооны хэвлэлийн бага хурал зохион байгуулсан.<br>- Телевиз, холбогдох газруудын хүсэлтээр монгол аман зохиол, "Жангар" туулийг сурталчлах, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор 6 нэвтрүүлэгт оролцсон. Жишээлбэл, монгол аман зохиол судлалын бодлогын асуудлаар 2021 оны 9-р сарын 2-ны өдөр UBS телевизийн Судлагдахуун нэвтрүүлэгт оролцжээ. Монгол Улсын Үндэсний номын сангийн цуврал подкастаар Жангар туулийн талаар 30 орчим минутын яриа өгсөн нь тус байгууллагын цахим хуудаст байршжээ. |

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **2.1** | Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвших болсон үндсэн шалтгаан даатгуулагчид буюу нийт хөдөлмөр эрхэлж байгаа ажилчдыг төлөөлөн энэхүү даатгалын үр өгөөж, ашиг шимийг тэдэнд илүү ээлтэй байдлаар шийдвэрлүүлэхэд оршино.<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснөөр иргэд хэвтэн эмчлүүлэх, амбулаторийн тусламж, үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт, өндөр өртөгт мэс заслын тусламж үйлчилгээ, хорт хавдрын хими туяаны эмчилгээ зэрэг үйлчилгээнүүдийг авах эрхтэй ч даатгуулагчид эдгээр үйлчилгээний талаар бүрэн мэдээлэлгүйн улмаас хувиасаа төлбөр төлөн эмчлүүлэх, өндөр өртөгтэй эм тариаг хөнгөлөлтгүй үнээр худалдан авах, гадаадын өндөр хөгжилтэй улс оронд өртөг өндөр эмчилгээ хийлгэх зэргээр хохирсоор байна.<br>Тиймээс үр ашиг, хүртээмж өндөртэй хувийн эрүүл мэндийн даатгалууд нэвтэрч өрсөлдөөн ихсэж байгаа өнөө цагт даатгал төлсөн иргэдэд үйлчлэх үйлчилгээг илүү сайжруулах, боловсронгүй болгох, даатгал төлснөөр авч болох үйлчилгээний талаарх мэдээллийг нийтэд түгээх, зөвлөмж гарган ажиллах шаардлагатай байна. |

| | |
|---|---|
| | Хорт хавдрын эмчилгээг төрөөс 100% даадаг болсон хэдий ч хавдрын эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ учир дутагдалтай байгаа тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 06 дугаартай “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллахад анхаарна.<br>Эрүүл мэндийн даатгалын мөнгөн хөрөнгийг даатгуулагчдад хэрхэн үр өгөөжтэй байдлаар ашиглах талаар санал санаачилга гарган ажиллана. |

**Хавсралт:**

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

-Төрийн албан хаагчийн анкет;
-Боловсролын зэргийн дипломын хуулбар;
-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
-Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: .......... Түдэв ..........................................
Өөрийн нэр: .......... Баясгалан ..........................................
Гарын үсэг: .......... Т.Баясгалан ..........................................
Он, сар, өдөр: .......... 2023-03-17 ..........................................

--- оОо ---